

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**БУЛГАН СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/1/СТА-ТШЗСН

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsuren.A@audit.gov.mn Гэрээт аудитор: Д.Нарантуул Утас: 70432545 цахим хаяг: Narantuul.d@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ТБОНӨХБАҮХАТ</i>	<i>Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай</i>
<i>ЭМДС</i>	<i>Эрүүл мэндийн даатгалын сан</i>
<i>ЭМЯ</i>	<i>Эрүүл мэндийн яам</i>
<i>УТХО</i>	<i>Улсын төсвийн хөрөнгө оруулалт</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

## Агуулга

<b>1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ .....</b>	<b>3</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	5
2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	6
2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	7
2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН.....	7
/төгрөгөөр/.....	9
2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/ .....	9
2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН .....	11
3.АУДИТЫН ТАЙЛАН .....	11
3.1. Ерөнхий зүйл .....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	12
3.4. Материаллаг байдал .....	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	15
3.7. Шилэн дансны мэдээлэл .....	16
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
3.9. Аудитын илрүүлэлт .....	17
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
.....	
4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	
5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ .....	23

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ

 <b>ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР</b> 84000 Цамбагарав бяс Жаргалант сум, Ховд Утас: 978-70433061, Факс: 978-70433061 E-mail: khovd@audit.gov.mn	<b>БУЛГАН СУМЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГА Б.БАТБААТАР ТАНАА</b>
2021-03-18 № 2/165 танай _____ -ны № _____ -т	
<b>АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ</b>	
<b>Сөрөг дүгнэлт</b>	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөллийн улмаас Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаатай, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулаагүй байна.</p>	
<b>Дүгнэлтийн үндэслэл</b>	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<b>Бусад мэдээлэл</b>	
<p>Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар үр дүн, хэрэгжилт, эмч эмнэлгийн ажилтны ёс зүйн байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.</p> <p>Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.</p>	
<b>Аудитын гол асуудал</b>	
<p>Санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, өмнөх санхүүгийн тайлангаар өгөгдсөн зөвлөмж хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, үнэ төлбөргүй нэмэгдсэн хөрөнгө бүртгээгүй, тайлант оны элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн, шатахуун болон бусад бараа материалын зарцуулалтад тавих дотоод хяналтгүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, жолоочийн тооцоо бодоогүй, байгууллагын даргын тушаалаар баталсан дотоод хяналтын баг хийх ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг 7 сараас хойш цахим сайтад байршуулаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8 –д "төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх" 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 6.4.2-д "төрийн</p>	
<b>021020721</b>	

чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5.-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор.", 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор.", 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 3.2.14.-д "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар.", 3.1.16-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар" гэж заасныг тус тус зөрчиж аудитын "Оршин байх", "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Эрх бэ үүрэг", "Үнэн зөв байдал", "толилуулга ба тодруулга", "үнэлгээ", "хэмжилт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>92,577,017.00</u></b>	<b><u>269,556,179.35</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	5,968,429	19,119,100
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,830,000	4,234,625
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	4,138,429	14,884,475
3351	Байгууллагаас авах авлага	-	10,762,580
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,138,429	4,121,895
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	86,608,588	250,437,079.35
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	31,143,461	89,043,152.35
35110	Тусгай зориулалттай материал	-	5,155,250.00
35130	Эм боох материал	31,143,461	83,887,902.35
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	55,465,127	161,393,927.00
35410	Бичиг хэргийн материал	-	1,552,750.00
35420	Аж ахуйн материал	398,800	10,266,660
35440	Түлш, шатах тослох материал	48,531,508	129,543,958
35460	Хүнсний материал	1,345,200	14,782,940
35470	Бусад хангамжийн материал	5,189,619	5,247,619
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,382,322,194.56</u></b>	<b><u>7,308,359,412.64</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	7,382,322,194.56	7,308,359,412.64
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	7,368,818,194.56	7,294,855,412.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,240,172,123	7,240,172,123
39202	Хуримтлагдсан элэгдэл	(179,795,793)	(354,662,529)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	153,761,354	135,449,054
39204	Хуримтлагдсан элэгдэл	(130,405,087.08)	(123,041,159.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	840,232,144	1,010,636,108
39206	Хуримтлагдсан элэгдэл	(572,224,643.04)	(626,416,062.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	69,104,087	69,104,087
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,025,990.32)	(56,386,208.57)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	13,504,000	13,504,000
39301	Програм хангамж	275,000	275,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	(275,000)	(275,000)
39303	Бусад биет бус хөрөнгө	13,504,000	13,504,000
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>7,474,899,211.56</u></b>	<b><u>7,577,915,591.99</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b><u>2,971,327.37</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	2,971,327.37
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>-</b>	2,971,327.37
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	1,110,596.61
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	<b>-</b>	1,860,730.76
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,604,930.76
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	255,800.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,474,899,211.56</u></b>	<b><u>7,574,944,264.62</u></b>

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>7,474,899,211.56</b>	<b>7,574,944,264.62</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	470,965,819	470,965,819
51101	Өмч: - төрийн	470,965,819	470,965,819
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>6,819,635,145.19</b>	<b>6,919,680,198.25</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	6,819,635,145.19	6,821,322,490.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	98,357,708.06
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	184,298,247.37	184,298,247.37
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,474,899,211.56</b>	<b>7,577,915,591.99</b>

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>8,880,916,990</b>	<b>2,015,199,181</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,313,762,737</b>	<b>166,960,357</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,313,762,737	166,060,357
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,313,762,737	166,060,357
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,905,617	13,668,873
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,298,857,120	152,391,484
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	900,000
122001	Хандив тусламж /дотоод/	-	900,000
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,567,154,253</b>	<b>1,848,238,824</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,068,466,400	1,299,040,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,068,466,400	1,299,040,200
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,035,300	12,642,090
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,535,300	12,642,090
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	491,652,553	536,556,534
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	491,652,553	536,556,534
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,782,399,036.94</b>	<b>1,370,069,194.98</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,782,399,036.94</b>	<b>1,370,069,194.98</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,781,039,036.94	1,369,990,344.11
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	909,838,147	558,775,808.67
210101	Үндсэн цалин	846,494,256	558,775,808.67
210102	Нэмэгдэл	1,551,761	
210104	Урамшуулал	61,792,130	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	77,346,098.20	92,531,832.37
210201	Тэтгэврийн даатгал	77,346,098.20	92,531,832.37
210202	Тэтгэмжийн даатгал		
210203	ҮОМШӨ-ний даатгал		
210204	Ажилгүйдлийн даатгал		
210205	Эрүүл мэндийн даатгал		
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	-	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	89,245,724.80	66,262,148.70

210301	Гэрэл, цахилгаан		29,236,098.80
210302	Түлш, халаалт	88,405,724.80	32,649,250
210303	Цэвэр, бохир ус	840,000	4,376,799.90
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>92,778,351</b>	<b>76,024,867</b>
210401	Бичиг хэрэг	4,847,571	7,207,250
210402	Тээвэр, шатахуун	62,710,760	50,557,370
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,281,310	2,570,607
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	21,223,810	13,606,140
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,714,900	2,083,500
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>298,818,666</b>	<b>319,261,289.41</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	266,837,068	281,778,839.41
210502	Хоол, хүнс	25,651,098	30,546,450
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,330,500	6,936,000
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,065,857</b>	<b>5,189,200</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,476,120	-
210604	Урсгал засвар	5,589,737	5,189,200
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,219,700</b>	<b>1,274,000</b>
210702	Дотоод албан томилолт	1,219,700	1,274,000
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>5,285,700</b>	<b>9,339,152</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	4,337,533
210803	Даатгалын үйлчилгээ	623,700	272,850
210804	Тээврийн хэрэгслийн татвар	712,800	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	151,500	132,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,614,800	4,596,769
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>297,440,792.94</b>	<b>241,332,045.96</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	297,440,792.94	241,332,045.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,360,000</b>	<b>78,850.87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,360,000</b>	<b>-</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>78,850.87</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	78,850.87
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>7,098,517,953.06</u></b>	<b><u>645,129,986.02</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>(3,034,699.96)</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>(3,034,699.96)</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	(3,034,699.96)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>7,831,597,508.24</u></b>	<b><u>642,095,286.06</u></b>

**2.3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН /төгрөгөөр/**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1,582,059,870</u></b>	<b><u>1,862,807,697</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>14,905,617</u></b>	<b><u>14,568,873</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,905,617	13,668,873
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	14,905,617	13,668,873
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,905,617	13,668,873
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	-	900,000
122001	Хандив тусламж /дотоод/	-	900,000
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>1,567,154,253</u></b>	<b><u>1,848,238,824</u></b>

<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,068,466,400	1,299,040,200
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,068,466,400	1,299,040,200
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,035,300	12,642,090
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,535,300	12,642,090
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	491,652,553	536,556,534
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	491,652,553	536,556,534
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,582,059,870</b>	<b>1,862,807,697</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,582,059,870</b>	<b>1,862,807,697</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,580,699,870</b>	<b>1,862,728,846.13</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	901,069,170	1,056,052,248.43
210101	Үндсэн цалин	524,785,700	553,430,270.43
210102	Нэмэгдэл	278,691,900	372,624,207
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,738,000	43,453,500
210104	Урамшуулал	51,853,570	86,544,271
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	112,711,800	137,710,764.90
210201	Тэтгэврийн даатгал	76,644,000	96,595,164.90
210202	Тэтгэмжийн даатгал	9,016,900	10,278,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,213,600	8,223,100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,803,400	2,055,800
210205	Эрүүл мэндийн даатгал	18,033,900	20,557,800
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	163,939,400	148,107,998.80
210301	Гэрэл, цахилгаан	30,679,400	33,716,098.80
210302	Түлш, халаалт	117,400,000	108,615,000
210303	Цэвэр, бохир ус	15,860,000	5,776,900
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	62,413,600	71,397,472
210401	Бичиг хэрэг	696,800	6,942,100
210402	Тээвэр, шатахуун	48,987,400	49,595,495
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,205,300	2,837,707
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,907,800	5,692,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,616,300	6,329,470
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	314,469,500	398,827,980
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	282,434,476	346,335,190
210502	Хоол, хүнс	26,996,300	41,501,090
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,038,724	10,991,700
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,862,500	27,498,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,813,500	23,368,500
210604	Урсгал засвар	5,049,000	4,129,500
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,219,700	1,482,300
210702	Дотоод албан томилолт	1,219,700	1,482,300
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,014,200	21,652,082
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	9,831,263
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	346,500	-
210803	Даатгалын үйлчилгээ	623,700	272,850
210804	Тээврийн хэрэгслийн татвар	712,800	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	151,500	132,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,777,800	8,915,969

210807	Газрын төлбөр	120,000	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,182,900	2,500,000
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,360,000</b>	<b>78,850.87</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,360,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	78,850.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	78,850.87

#### 2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	470,965,819	114,251,154	(222,149,795.87)	363,067,177.13
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>470,965,819</b>	<b>114,251,154</b>	<b>(222,149,795.87)</b>	363,067,177.13
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	7,831,597,508.24	7,831,597,508.24
C08	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>470,965,819</b>	<b>184,298,247.37</b>	<b>6,819,635,145.19</b>	7,474,899,211.56
D01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>470,965,819</b>	<b>184,298,247.37</b>	<b>6,819,635,145.19</b>	7,474,899,211.56
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	1,687,345	1,687,345
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>470,965,819</b>	<b>184,298,247.37</b>	<b>6,821,322,490.19</b>	<b>7,476,586,556.56</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	98,357,708.06	98,357,708.06
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>470,965,819</b>	<b>184,298,247.37</b>	<b>6,919,680,198.25</b>	<b>7,574,944,264.62</b>

#### 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,575,649,500	1,575,024,570	1,863,819,100	1,849,186,756.13
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,575,649,500	1,575,024,570	1,863,819,100	1,849,186,756.13
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,574,289,500	1,573,664,570	1,862,499,100	1,849,186,756.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	901,694,100	901,069,170	1,061,637,300	1,056,052,248.43
210101	Үндсэн цалин	524,785,700	524,785,700	556,286,400	553,430,270.43
210102	Нэмэгдэл	278,691,900	278,691,900	378,681,700	372,624,207
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,738,000	45,738,000	45,738,000	43,453,500
210104	Урамшуулал	52,478,500	51,853,570	80,931,200	86,544,271

<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	112,711,800	112,711,800	138,765,300	137,710,764.90
210201	Тэтгэврийн даатгал	76,644,000	76,644,000	97,649,700	96,595,164.90
210202	Тэтгэмжийн даатгал	9,016,900	9,016,900	10,278,900	10,278,900
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,213,600	7,213,600	8,223,100	8,223,100
210204	Ажилгүйдлийн даатгал	1,803,400	1,803,400	2,055,800	2,055,800
210205	Эрүүл мэндийн даатгал	18,033,900	18,033,900	20,557,800	20,557,800
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	163,939,400	163,939,400	146,168,700	149,396,023.80
210301	Гэрэл, цахилгаан	30,679,400	30,679,400	31,760,500	33,716,098.80
210302	Түлш, халаалт	117,400,000	117,400,000	108,615,000	109,903,025
210303	Цэвэр, бохир ус	15,860,000	15,860,000	5,793,200	5,776,900
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	60,048,300	60,048,300	71,878,500	69,450,947
210401	Бичиг хэрэг	696,800	696,800	4,109,000	6,942,100
210402	Тээвэр, шатахуун	46,622,100	46,622,100	50,422,100	47,648,970
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,205,300	3,205,300	3,205,300	2,837,707
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,907,800	5,907,800	8,525,800	5,692,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,616,300	3,616,300	5,616,300	6,329,470
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	314,469,500	314,469,500	389,288,200	386,844,390
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	280,721,600	282,434,476	331,432,600	334,351,600
210502	Хоол, хүнс	26,996,300	26,996,300	45,104,600	41,501,090
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,751,600	5,038,724	12,751,000	10,991,700
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,192,500	13,192,500	23,019,300	26,598,000
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,143,500	8,143,500	17,970,300	22,468,500
210604	Урсгал засвар	5,049,000	5,049,000	5,049,000	4,129,500
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	1,219,700	1,219,700	2,500,000	1,482,300
210702	Дотоод албан томилот	1,219,700	1,219,700	2,500,000	1,482,300
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,014,200	7,014,200	29,241,800	21,652,082
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж			12,627,300	9,831,263
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	346,500	346,500	450,000	-
210803	Даатгалын үйлчилгээ	623,700	623,700	272,900	272,850
210804	Тээврийн хэрэгслийн татвар	151,500	712,800	712,800	-
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	712,800	151,500	132,000	132,000
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,777,800	3,777,800	12,327,800	8,915,969
210807	Газрын төлбөр	120,000	120,000	120,000	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	99,000	99,000	99,000	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,182,900	1,182,900	2,500,000	2,500,000

213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,360,000	1,360,000	1,320,000	-
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,360,000	1,360,000	1,320,000	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000	1,360,000	1,320,000	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,575,649,500	1,575,024,570	1,863,819,100	1,849,186,756.13
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,068,466,400	1,068,466,400	1,299,040,200	1,298,961,349.13
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,068,466,400	1,068,466,400	1,299,040,200	1,298,961,349.13
1340	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	491,683,100	491,652,553	549,278,900	536,556,534
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	491,683,100	491,652,553	549,278,900	536,556,534
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	15,500,000	14,905,617	15,500,000	13,668,873
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,500,000	14,905,617	15,500,000	13,668,873
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	69	69	69	69
620001	Удирдах ажилтан	1	1	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	64	64	64	64
620003	Үйлчлэх ажилтан	4	4	4	4
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	50	50	50	50
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19	19	19

## 2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>7,142,760</b>	<b>12,642,090</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>7,142,760</b>	<b>12,642,090</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	7,142,760	12,642,090
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,472,760	658,500
210402	Тээвэр, шатахуун	2,472,760	658,500
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	4,170,000	11,983,590
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,170,000	11,983,590
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	500,000	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000	-
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	7,142,760	12,642,090
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	7,142,760	12,642,090
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,642,760	12,642,090

## 3.АУДИТЫН ТАЙЛАН

### 3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг эрхлэгч эмч Б.Батбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд эм, бичиг хэрэг, аж ахуйн материал болон шатахууны худалдан авалт зарцуулалт, үндсэн хөрөнгө, улирлын мөнгөн урамшуулал, илүү цаг олголт, дотоод хяналт, тооллого хийж тооцоо бодох талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 11-нээс 2021 оны 03 дугаар сарын 18-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нарантуул хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь Ковид -19 цар тахлын үеийн хөл хорио тогтоолт, нягтлан бодогч солигдож 2020 оны 1-6 дугаар сарын санхүүгийн баримт Авилагтай тэмцэх газарт шалгагдаж байгаа зэргээс шалтгаалан 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2021 оны 03 сарын 10-ны өдөр Төрийн аудитын байгууллагад ирүүлж хуулийн хугацаа хоцроосноос зэргээс хамаарч аудитын тайлангийн хугацаа хоцорсон болно.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Булган сумын Нэгдсэн эмнэлэг нь “Ард иргэдэд эрүүл аж төрөх ёсыг дадал хэвшил болгосон, нотолгоонд суурилсан, анхан шатны тусламж үйлчилгээг аюулгүй, чанартай үзүүлэхэд оршино” гэсэн зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн үйл ажиллагааны чиглэл нь төв хөдөөгийн хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх гэж тодорхойлжээ.

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Булган сумын Нэгдсэн эмнэлэг нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь өөрийн байгууллагын онцлог үйл ажиллагааг тусгасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулаагүй байна.

ЭМЯ -наас 2020 оны санхүүгийн баримтад дотоод хяналт хийгдээгүй, 2020 оны 5 сард аймгийн ЭМГ-аас ирүүлсэн албан тоо бичгийн дагуу Ховд аймаг дахь Төрийн аудитын газраас 2015-2020 оны 4 дүгээр сар дуусталх хугацааны цалин хөлстэй холбоотой асуудлаар шалгалт хийгдэж холбогдох асуудлыг АТГ-т хүргүүлсэн, сумын Төрийн сангаас өдөр тутмын хяналт хэрэгжүүлсэн байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр **нийт зардлыг** сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 8880917.0 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 88809.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогоос 2014299.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 20143.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

Материаллаг байдлын түвшин гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатнаас багаа байгаа шалтгаан нь 2019 онд Нэгдсэн эмнэлгийн барилга шинээр ашиглалтад орж бүртгэсэнтэй холбоотой өндөр тооцогдсон болно.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 103016.4 мянган төгрөгөөр буюу 1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөр, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцооны данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Авлага	5,968.4	19,119.1	13,150.7
Бараа материал	86,608.6	250,437.1	163,828.5
Үндсэн хөрөнгө	7,382,322.2	7,308,359.4	(73,962.8)
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>7,474,899.2</b>	<b>7,577,915.6</b>	<b>103,016.4</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		2,971.3	2,971.3
Цэвэр хөрөнгө, өмч	7,474,899.2	7,574,944.3	100,045.1
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,474,899.2</b>	<b>7,577,915.6</b>	<b>103,016.4</b>

Авлага дансны үлдэгдэл 19119.1 мянган төгрөг болж 13150.7 мянган төгрөгөөр өссөн шалтгаан нь бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас авах эм, аж ахуйн материал, шатахууны үнийг илүү төлсөнтэй холбоотой нэмэгдсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 250437.1 мянган төгрөг болж 163828.5 мянган төгрөгөөр өссөн нь түлээ нүүрс, хүнсний материалын үлдэгдэл өмнөх оноос их хэмжээгээр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Бараа материалын үлдэгдэлд өндөр дүнтэй нөлөөлж байгаа гол шалтгаан нь түлээ нүүрсний материалын үлдэгдэл 107828.0 мянган төгрөгийн буюу 744.44 тонн нүүрсийг 2019-

2020 онуудад худалдан авсан нь тодорхой бус, хүнсний материалын худалдан авалт зарцуулалтыг өвчтөнд хэрэглэсэн хоолны таланоос түүвэрлэхэд тулгахад санхүүгийн тайланд тусгасан үлдэгдлээс 2082.9 мянган төгрөгөөр зөрүүтэй байгааг нягтлан бодогч нь жижүүрт гардаг эмч ажилчдад оройн хоол, өглөөний цайнд зарцуулсан гэх аман тайлбарыг өгсөн, байгууллагын даргын тушаал шийдвэргүй, мөн хор саармагжуулах зорилгоор хэнд хүнд сард хэчнээн хэмжээний сүү олгосон нь тодорхой бус, нотлох анхан шатны баримтгүй, эд хариуцагчийн тайлангүй учир баталгаажуулах боломжгүй байгаа нь дотоод хяналтгүй жилийн эцэст тооллого хийж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

№	Үзүүлэлт	Дүн
<b>1</b>	<b>Оны эхний үлдэгдэл</b>	<b>86,608.6</b>
2	Нэмэгдсэн	597,487.5
2.1	Худалдан авсан	593,305.6
2.2	Хандиваар	4,181.9
3	Хасагдсан	433,659.0
3.1	Худалдсан, зарцуулсан	433,659.0
<b>4</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>250,437.1</b>

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 8317048.7 мянган төгрөг, оны эцэст 8469140.4 мянган төгрөг болж 152091.7 мянган төгрөгөөр өссөн нь ЭМЯ-ны хөрөнгө оруулалт болон Бельги улсын засгийн газрын тусламжаар 148209.6 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй нэмэгдсэн, төсвийн хөрөнгөөр 22194.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж аппарат худалдан авсан нийт 170404.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн, аймгийн ИТХ-ын 2020 оны 112 дүгээр тогтоолоор аймгийн Орон нутгийн өмчийн газарт тээврийн хэрэгсэл шилжүүлсэнтэй хасагдсан байна.

№	Үзүүлэлт	Дүн
<b>1</b>	<b>Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл</b>	<b>8,317,048.7</b>
2	Нэмэгдсэн	170,404.0
2.1	Худалдан авсан	22,194.4
2.2	Хандиваар	148,209.6
3	Хасагдсан	18,312.3
3.1	Акталсан	18,312.3
<b>4</b>	<b>Үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>8,469,140.4</b>
6	Хуримтлагдсан элэгдлийн оны эхний үлдэгдэл	934,726.5
801	Элэгдлийн зардал тайлант хугацааны	241,586.4
	Дансны хасалт	15,277.6
10	Хуримтлагдсан элэгдлийн эцсийн үлдэгдэл	1,161,035.3
<b>11</b>	<b>Үлдэгдэл өртөг</b>	<b>7,308,105.1</b>

Өр төлбөр оны эцэст 2971.3 мянган төгрөгөөр буюу эм, хүнсний болон бичиг хэргийн материалын өглөгөөр өссөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7574944.3 мянган төгрөг болж 100045.1 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх үеийн үр дүн данс руу 1687.3 мянган төгрөгийн залруулах бичилт хийгдсэн, тайлант онд 98357.7 мянган төгрөгийн ашигтай гарсан зэргээс шалтгаалж байна.

Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6865717.8 мянган төгрөгөөр буюу 77.3 хувиар буурсан байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 6866617.8 мянган төгрөгөөр буюу 77.3 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 230573.8 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт орлого

5606.8, ЭМДС-аас авах санхүүжилт 44903.9 мянган төгрөгөөр тус тус өссөн, үнэ төлбөргүй орлого 7146465.6, нүдсэн үйл ажиллагааны орлого 1236.7 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>8,880,917.0</b>	<b>2,015,199.2</b>	<b>(6,865,717.8)</b>
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	14,905.6	13,668.9	(1,236.7)
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,298,857.1	152,391.5	(7,146,465.6)
Хандив тусламж /дотоод/		900.0	900.0
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,068,466.4	1,299,040.2	230,573.8
Нэмэлт санхүүжилтийн орлого	7,035.3	12,642.1	5,606.8
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	491,652.6	536,556.5	44,903.9

Нийт зардал өмнөх оноос 74929.1 мянган төгрөгөөр буюу 4 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, тогтмол зардлууд тус тус өссөн, байр ашиглалттай холбоотой урсгал шилжүүлэг, хангамж, бараа үйлчилгээний бусад хангамж бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа, үйлчилгээний бусад зардлууд буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн холбоотой байна.

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	Өөрчлөлт
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,839,132.0</b>	<b>1,914,061.1</b>	<b>74,929.1</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	909,838.1	1,061,397.8	151,559.7
2102	Ажил олгогчоос даатгалд төлөх	103,569.6	133,647.4	30,077.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	119,755.2	66,262.1	(53,493.1)
2104	Хангамж, бараа материалын зардал	92,778.3	76,024.9	(16,753.4)
2105	Нормативт зардал	298,818.7	319,261.3	20,442.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,065.9	5,189.2	(3,876.7)
2107	Томилолт, зочны зардал	1,219.7	1,274.0	54.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	5,285.7	9,339.1	4,053.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	297,440.8	241,586.4	(55,854.4)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,360.0	78.9	(1,281.1)

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1841389.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1841389.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1863819.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 1299040.2 мянган төгрөгийг

улсын төсвийн санхүүжилтээс, 549278.9 мянган төгрөгийг, ЭМД-ын сангаас 549278.9 мянган төгрөг, 15500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвийн санхүүжилт 1299040.2 мянган төгрөг, ЭМД-ын сангаас 536556.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 13668.9 мянган төгрөг, нийт 1849265.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1849186.8 мянган төгрөгийг зарцуулж 78.8 мянган төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсвөөс ЭМД-ийн сангаас авах санхүүжилтийг 12722.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авч чадаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлогыг 1831.1 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн, 100160220001 тоот дансанд үндсэн үйл ажиллагааны орлогын 4733.6 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтийн данс руу шилжүүлэн зарцуулсантай холбоотой өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан харагдаж байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1849186.8 мянган төгрөг буюу 99.2 хувьтай зарцуулсан байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээ 78.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	78.8
	ДҮН	78.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансаар Монголын сумын эмч мэргэжилтнүүдийн холбооноос сорьц тээвэрлэх зардал 658.5, НДХ-ээс жирэмсэн амаржсаны тэтгэмж 1472.2, ЭМГ-аас эмийн зардлын санхүүжилт 7250.0, үндсэн үйл ажиллагааны орлого байгууллагын үндсэн дансанд орсон 4733.6 мянган төгрөг бүгд 14114.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 11983.6 мянган төгрөгийн эмийн зардалд зарцуулж, сорьц тээврийн шатахууны зардалд 658.5, жирэмсэн амаржсаны тэтгэмжид 1472.2 бүгд 14114.3 мянган төгрөгийн зарлага гаргаж нэмэлт санхүүжилтийн тайланд 1472.2 мянган төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмжийг цэвэрлэж тайлагнасан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 167 мэдээллээс, хугацаандаа оруулсан 56 мэдээллийг оруулсан, 111 огт мэдээлээгүй, Шилэн дансны мэдээллийг хянахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого буюу зарлага, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлээгүй байна.

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 3 зөвлөмж өгөгдөж хэрэгжилт 33.3 хувьтай байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Акт	1	8,745.6	1	8,745.6	-	-	100
Зөвлөмж	3	6,187.2	1	6,187.2	2	-	33.3
Нийт дүн	4	14,932.8	2	14,932.8	2	-	

### 3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 980887.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 190770.3 мянган төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 790116.7 мянган төгрөгийн зөрчилд 3 зөрчилд 30612.7 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 521509.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 207593.1 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 112 тоот тогтоолоор аймгийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн 18312.3 мянган балансын үнэтэй, 15277.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй тээврийн хэрэгслээс хасаж бүртгээгүй,
2. Мөнгөн гүйлгээний болон санхүүгийн үр дүнгийн тайланд орлого 43398.6 мянган төгрөгөөр дутуу тусгасан,
3. Өглөг 1110.6 мянган төгрөг, авлага 1347.8 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй илэрхийлсэн,
4. Үнэ төлбөргүй нэмэгдсэн 42498.5 мянган төгрөг, худалдан авсан 900.0 мянган төгрөгийн хөрөнгө орлогод аваагүй,
5. Хөрөнгийн элэгдлийн зардал 1757.1 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
6. Балансаас балансад шилжүүлсэн хөрөнгийн 2780.4 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө худалдсаны гарзаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй,
7. Тайлант үеийн үр дүнг 63387.4 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг аудитын явцад залруулга хийгдлээ.

**Шийдвэрлэсэн нь:** Байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт асуудлын бүртгэлээр танилцуулан **190770.3** мянган төгрөгийн залруулга хийж, залруулсан албан тоот ирүүлсэн болно.

### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 582523.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3477.7 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 440700.3 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 138345.4 мянган төгрөгийн зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүллээ. Үүнд:

1. Эмнэлгийн даргын ажлын үр дүнг дүгнэснийг нотлох баримтгүй, улирлын мөнгөн урамшуулалд **1246.0** мянган төгрөгийг тушаал шийдвэргүй олгосон, НАОЛ ХХК-аас ямар үйл ажиллагаанд зарцуулсан нь тодорхой бус **636.5** мянган төгрөгийн хүнсний материал, **250.0** мянган төгрөгийн хонь худалдан авч төлбөрийг төлсөн өвчтөний хоол хүнсэнд

зарцуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.3-д "Төрийн өмчийн ЭМ-ийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгоходоо энэ журмын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, тухайн жилийн төсөвт уг урамшуулалд зориулан батлагдсан хөрөнгийн дүнд багтаан энэ журмын 3.10, 3.12-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын "үнэн зөв байдал", "бодитой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчилтэй холбоотой 2132.0 мянган төгрөгийг төлүүлэх төлбөрийн акт

2. 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 236 кг буюу нэг бүрийн үнэ 5700 төгрөгийн үнэтэй 1345.2 мянган төгрөгийн махны үлдэгдэлтэйгээр тайланд тусгасан 2020 онд зарцуулсныг нотлох баримтгүй, бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, эд хариуцагч нь ажлаас халагдсан ажлаа хүлээлгэн өгөөгүй байгаа нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ", 12.2.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед"* гэсэн заалттай нийцээгүй, аудитын "оршин байх", "хэмжилт", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

3. 2019 оны 9,12 дугаар сард эд хариуцагч нь 108.4 тонн буюу 15335.0 мянган төгрөгийн нүүрсийг нийлүүлсэн эсэх нь тодорхой бус, санхүүгийн баримтад байгаа анхан шатны баримтаар нотлогдохгүй, нүүрс нийлүүлэх гэрээ байгуулаагүй, 2019 оны 12 дугаар сард Төрийн банкны түр данснаас эд хариуцагчийн 110200294390 тоот данс руу 11800.0 мянган төгрөгийг шилжүүлэн бэлнээр авч ямар зардалд зарцуулсныг нотлох анхан шатны баримтгүй нийт 27135.0 мянган төгрөгийн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-д "хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед", 13.5-д "анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна", 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй аудитын "оршин байх", "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт

4. Тайлант онд худалдан авсан 440450.3 мянган төгрөгийн эм, хүнс, бичиг хэрэг, аж ахуйн болон түлээ нүүрсний материалын эд хариуцагчийн тайланг сар бүрээр гаргаагүй, санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, эм ороох боох материалын үлдэгдэл зөрүүтэй, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд ЭМЯ-ны Сайдын А/69 тоот тушаалын 1.6-д заасны дагуу оройн ээлжид хонож байгаа ажилчдад хоол хийж өгдөг гэсэн тайлбарыг нягтлан бодогч нь амаар өгч байгаа ч хэдэн ажилтанд хэчнээн нэр төрлийн хэдэн төгрөгийн материал зарцуулсныг нотлох анхан шатны баримтгүй, хор саармагжуулах зорилгоор ажилчдад сүү олгодог хэчнээн хүнд хэдэн литр сүү олгосныг нотлох анхан шатны баримтгүй, тушаал шийдвэргүй, тайлант онд худалдан авсан зарцуулсан хүнсний материалын тооцоог хийхэд үлдэгдэл зөрүүтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн

байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг бүртгэн авч хадгалах, түүнийг нэр төрөл, чанар, бүрдлийн хувьд бүрэн бүтэн байлгах, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр тавьж олгох, зэрэг бүхий этгээдийг эд хариуцагч гэнэ" гэсэн заалтуудыг мөрдөөгүй, аудитын "оршин байх", "хэмжилт", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5. 2019-2020 оны нүүрсний зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад санхүүгийн тайлан дахь нүүрсний үлдэгдлээс 80808.9 мянган төгрөгийн нүүрс бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, нотлох анхан шатны баримтууд бүрэн бус учир зарцуулалтыг хянах боломжгүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй Байтаг цагаан бургаст ХХК, Минж төгөл ХХК нь 2019, 2020 онуудад тус байгууллагад нүүрсийг бүрэн нийлүүлсэн эсэх нь тодорхой бус, байгууллагын санхүүгийн баримт дахь анхан шатны баримтуудаар бүрэн нотлогдохгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д "анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна"*, 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 12 дугаар зүйлийн 12.2-д "хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 12.2-д "эд хөрөнгө хариуцагч болон эд хөрөнгийн тооцоотой холбоотой ажилтан солигдох үед" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын "оршин байх", "эрх ба үүрэг", "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн байгууллага хүргүүлэн үргэлжлүүлэн шалгуулах албан шаардлага өгөх

6. Шилэн дансны мэдээллийг хянахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого буюу зарлага, дараа жилийн төсвийн төсөл, санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, хагас жилийн санхүүгийн тайлан, аудитын зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлээгүй, төсвийн хэмнэлт хэтрэлтийн шалтгаан тайлбарыг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1.3-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор,"; 6.1.4-д "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор,"; 6.1.6-д "төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр,"; Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын 3.2.14.-д "аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг жил бүрийн 7 дугаар сарын 1-ний дотор PDF форматаар,"; 3.1.16-д "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор PDF форматаар" гэсэн заалттай нийцэхгүй, аудитын батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн **207593.1** мянган төгрөгийн алдаа, зөрчилд 7 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Аудитыг гүйцэтгэж байх хугацаанд аймгийн Цагдаагийн газраас 2021 оны 3 сарын 09 өдрийн 464/72 тоот албан бичиг ирж тус байгууллагын 2019-2020 оны дулаан халаалтад зарцуулсан нүүрсний зарцуулалтын талаар шалгалт хийж дүгнэлт гаргаж өгөхийг хүссэн албан бичиг ирүүлсэн.

Бид аудитын хүрээнд 2020 оны нүүрсний зарцуулалтыг хянахад дараа алдаа зөрчил байгаа нь нотлогдож байгаа тул Цагдаагийн байгууллагаас тус асуудлуудад шинжээч томилон дүгнэлт гаргуулж нарийвчлан нягтлан шалгах шаардлагатай байна гэж үзэж, аудитын тайлангийн хуулбарыг хүргүүллээ. Үүнд.

- Тэнгэрийн шагай ХХК-д 3808.1 мянган төгрөгийн материалын үнэ, 3187.8 мянган төгрөгийн мэс заслын болон төрөхийн даавууны үнэнд, Минж төгөл ХХК-д 5237.6 мянган төгрөгийн шатахууны үнэ, Мөнхсүвдан гэрэл ХХК-д 15768.0 мянган төгрөгийн эмийн үнэ, Нэхст электроникс ХХК-д компьютерийн үнэ 2400.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч дээрх эм, материал, хөрөнгийг хүлээн авч зарцуулсныг нотлох боломжгүй эд хариуцагч нь ажлаас халагдсан, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, нотлох анхан шатны баримтгүй,

- Нүүрсний худалдан авалт, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй, худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй зохион байгуулаагүйгээс их хэмжээний нүүрс бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, Байтаг цагаан бургаст ХХК, Минж төгөл ХХК болон бусад бэлтгэн нийлүүлсэн аж ахуйн нэгж байгууллага, хувь хүмүүс нь 2019, 2020 онуудад тус байгууллагад нүүрсийг бүрэн нийлүүлсэн эсэх нь тодорхой бус, байгууллагын санхүүгийн баримт дахь анхан шатны баримтуудаар бүрэн нотлогдохгүй анхан шатны баримтаар нотлогдохгүй, байгаатай холбоотой хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах анхаарал татахуйц асуудлууд байна.

#### **4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

##### ***1.Өглөгийн данстай холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт: Өмнөх 2019 онд эм, хүнс, бичиг хэрэг, аж ахуйн материалыг худалдан авч зарцуулсантай холбоотой 83291.0 мянган төгрөгийн өр төлбөрийг 2020 онд төлж тайлант оны зардлаар хүлээн бүртгэсэн байна.

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, бэлтгэн нийлүүлэгч байгууллага бүрээр тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй байх, өглөг тусгаагүй байх

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", гэсэн заалтуудыг мөрдөх, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах,

1.3. Байгууллагаас өгсөн хариу: Хүлээн зөвшөөрсөн.

##### ***2. Шатахууны зарцуулалт, эд хариуцагчийн тайлан гаргахтай холбоотой асуудал***

2.1. Илрүүлэлт: Тайлант онд нийт 44661.2 мянган төгрөгийн шатахуун худалдан авсан, нягтлан бодогч нь жолоочийн тооцоо бодоогүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй, эмч ажилчдын Алтай таван богд

явахад 750 литр буюу 1507.5 мянган төгрөгийг зарцуулсан дотоод журам тусгаагүй, тушаал шийдвэргүй зарцуулсан дутагдал илэрлээ.

**2.2. Эрсдэл:** Эд хариуцагчийн тайлан гаргаагүй байх, жолоочийн тооцоо бодоогүй байх, хяналт хэрэгжүүлээгүй байх, дотоод журамд тусгаагүй байх

**2.3. Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 15-д Хариуцаж байгаа эд зүйлийг зохих хууль ёсны баримт материал бүрдсэн буюу удирдлагын шийдвэрээр зориулагдсан зүйлд нь өөрийн биеэр тавьж олгож, хяналт тавьж ажиллана, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 17-д Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид өгч байна" гэсэн заалтыг хэрэгжүүлэн сар бүрийн шатахууны тайлан гаргаж, жолоочийн тооцоог бодож хэвших

**2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

## **2. Улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулал, илүү цагийн хөлс олгох асуудалтай холбоотой асуудал**

**3.1. Илрүүлэлт:** Тайлант онд эмч ажилчдад улирлын мөнгөн урамшуулал олгохдоо ажил дүгнэснийг нотлох баримтгүй, байгууллагын даргын тушаал шийдвэргүй 42984.3 мянган төгрөг, жижүүрт гарсан эмч нарын энгийн өдрийн илүү цагийн хөлсийг 16 цагаар тооцон олгосон, жижүүрийн эмч нь дараагийн өдөр 4 цагийг биеэр эдэлж байгаа тул 29452.9 мянган төгрөгөөр зөрүүтэй олгосон зэрэг нийт 72437.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

**3.2. Эрсдэл:** Төсөв хэтрэх, эмч ажилчдад илүү цагийн хөлсийг буруу тооцож олгох, тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал олгох,

**3.3. Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Хөдөлмөрийн тухай 53 дугаар зүйлийн 53.1-д "Илүү цагаар болон долоо хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд 1.5 дахин, түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн цалин хөлс олгоно.", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.3-д "Төрийн өмчийн ЭМ-ийн байгууллага нь эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшуулал олгохдоо энэ журмын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтийг баримтлан ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, тухайн жилийн төсөвт уг урамшуулалд зориулан батлагдсан хөрөнгийн дүнд багтаан энэ журмын 3.10, 3.12-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно" гэсэн заалтуудыг мөрдөх, үр дүнг бодитой дүгнэж, тушаал шийдвэр гарган олгож хэвших

**3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

## **4. Үндсэн хөрөнгө худалдан авахтай холбоотой асуудал**

**4.1. Илрүүлэлт:** Сүлжээний "Фохоу" ХХК-аас тосон болон бүх биеийн бариа засал хийх аппарат худалдан авахдаа харьцуулалт хийгээгүй, худалдан авах гэрээ байгуулаагүй 5696.0 мянган төгрөгөөр тоног төхөөрөмж худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ.

**4.2. Эрсдэл:** Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх, нэн тэргүүний шаардлагагүй хөрөнгө бэлтгэх

**4.3. Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл

ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах,

**4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

#### **5. Үндсэн хөрөнгө худалдан авахтай холбоотой асуудал**

**5.1. Илрүүлэлт:** 2019 онд эмнэлгийн барилга шинээр баригдсантай холбоотой сургалтын танхимын тохижуулах зорилгоор эмч ажилчдаас 1 өдрийн цалингийн хандиваар тавилга эд хогшил хийлгэсэн боловч хэдэн нэр төрлийн хурлын ширээ, индэр, ханын стенк зэрэг тавилга эд хогшил хийлгэж хэнд хүлээлгэн өгсөн, хүлээн авсан эзэн болон үнийн талаар мэдээлэл тодорхой бус байгаагаас шалтгаалан данс бүртгэлд тусгаагүй зөрчил илэрлээ.

**5.2. Эрсдэл:** Хандиваар ирсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байх, хөрөнгө дутах, эзэнгүйдэх

**5.3. Өгсөн зөвлөмж:** Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", комисс томилон хөрөнгийг хүлээн авч данс бүртгэлд тусгах

**5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

#### **6. Тооллого хийх асуудалтай холбоотой асуудал**

**6.1. Илрүүлэлт:** Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй зарим нэр төрлийн хөрөнгө, бараа материал бодит оршин байгаа эсэх нь тодорхой бус байгаа зөрчил илэрлээ.

**6.2. Эрсдэл:** Үндсэн хөрөнгө, бараа материалд тооллого хийгээгүй байх, үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байх

**6.3. Өгсөн зөвлөмж:** Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70 дугаар зүйлийн 70.2.2-д "түүхий эд, материал, түлш, сэлбэг, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6-д "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1-д "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг заавал хийнэ" гэж заасны дагуу хөрөнгө болон бараа материалыг жилд 2 удаа тооллого хийж үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах,

**6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

#### **7. Дотоод хяналттай холбоотой асуудал**

**7.1. Илрүүлэлт:** Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны А/17 тоот тушаалаар "Дотоод хяналтын баг" томилсон боловч хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгүй, ажлын тайлангүй байгаа нь дотоод хяналт хэрэгжээгүй байна.

**7.2. Эрсдэл:** Дотоод хяналт хэрэгжүүлээгүй байх

**7.3. Өгсөн зөвлөмж:** Засгийн газрын 311 дүгээр тогтоолын 1.5-д "энэ журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө", 3.5-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь хяналтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд 1 доошгүй удаа тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ", 3.6-д "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг

гүйцэтгэнэ” байгууллагын дотоод журмын 4-ийн 4.16-д "Байгууллага дотоод хяналт шалгалтыг хамт олны хурлаар хэлэлцэж, байгууллагын даргын тушаалаар батлагдсан /дотоод хяналт шалгалтын журмын дагуу зохион байгуулна. 4.17. Байгууллагын даргын шийдвэрээр орон тооны бус байнгын дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтан томилно. 4.18. Дотоод хяналтын шалгалтын ажилтанд хийсэн ажлын үр дүн, идэвх санаачилга, илрүүлсэн зөрчил зэргийг харгалзан үндсэн цалингийн 10-20 хувь хүртэлх хувийн урамшуулал улиралд нэг удаа олгоно" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах, дотоод хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэн хамт олонд мэдээлэх,

7.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо:	Аудитын нэр:	<b>Булган сумын Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2021			ХОА-2021/1/СТА-ТШЗСН
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Булган сумын Нэгдсэн эмнэлэг</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	
1	Мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй орлого, хандивын орлого дутуу тусгасан	43398.6	Залруулга хийх	Эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
2	Бельги улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банкны төсөл хөтөлбөрөөр ЭМЯ-аас хуваарилсан зайн оношилгооны тоног төхөөрөмж, хандивын мөнгөөр худалдан авсан хөрөнгийг орлогод аваагүй	43398.6	Залруулга хийх		
3	Аймгийн ИТХ-ын 2020 оны 112 тоот тогтоолоор Ланд ровер дефендер маркийн тээврийн хэрэгслийн Орон нутгийн өмчийн газарт шилжүүлсэн ч санхүүгийн тайланд тусгаагүй	33589.9	Залруулга хийх		
4	Шилжүүлсэн хөрөнгийн гарзыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй	2780.4	Залруулга хийх		
5	Өмнөх онд НИК ХХК-аас авах авлагыг тайланд тусгаагүй	1347.8	Залруулга хийх		
6	2020 онд нарийн мэргэжлээр суралцаж байгаа эмч нартай байгуулсан гэрээнд заасны дагуу 3 сарын цалин гаргаж НДШ-ийн тайланд кодыг буруу сонгож шимтгэлийн тооцоог зөрүүтэй хийсэнтэй холбоотой өрийг тусгаагүй орхигдуулсан	1110.6	Залруулга хийх		
7	Тайлант оны элэгдлийн зардал, тайлант үеийн үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн	65144.5	Залруулга хийх		

8	Эмнэлгийн даргын ажлын үр дүнг дүгнэснийг нотлох баримтгүй, улирлын мөнгөн урамшуулалд <b>1246.0</b> мянган төгрөгийг тушаал шийдвэргүй олгосон, НАОЛ ХХК-аас ямар үйл ажиллагаанд зарцуулсан нь тодорхой бус <b>636.5</b> мянган төгрөгийн хүнсний материал, <b>250.0</b> мянган төгрөгийн хонь худалдан авч төлбөрийг төлсөн өвчтөний хоол хүнсэнд зарцуулаагүй дутагдал байна.	2132.5	Төлбөрийн акт	Эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
9	2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 236 кг буюу нэг бүрийн үнэ 5700 төгрөгийн үнэтэй 1345.2 мянган төгрөгийн махны үлдэгдэлтэйгээр тайланд тусгасан 2020 онд зарцуулсныг нотлох баримтгүй, эд хариуцагч нь ажлаас халагдсан ажлаа хүлээлгэн өгөөгүй байна.	1345.2	Төлбөрийн акт	Эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
10	2019 оны 9,12 дугаар сард эд хариуцагч нь 108.4 тонн буюу 15335.0 мянган төгрөгийн нүүрсийг нийлүүлсэн эсэх нь тодорхой бус, санхүүгийн баримтад байгаа анхан шатны баримтаар нотлогдохгүй, нүүрс нийлүүлэх гэрээ байгуулаагүй, 2019 оны 12 дугаар сард Төрийн банкны түр данснаас эд хариуцагчийн 110200294390 тоот данс руу 11800.0 мянган төгрөгийг шилжүүлэн бэлнээр авч ямар зардалд зарцуулсныг нотлох анхан шатны баримтгүй	27135.0	Төлбөрийн акт	Эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
11	Тайлант онд худалдан авсан эм, хүнс, бичиг хэрэг, аж ахуйн болон түлээ нүүрсний материалын эд хариуцагчийн тайланг сар бүрээр гаргаагүй, санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, эм ороох боох материалын үлдэгдэл зөрүүтэй, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдэд ЭМЯ-ны Сайдын А/69 тоот тушаалын 1.6-д заасны дагуу оройн ээлжид хонож байгаа ажилчдад хоол хийж өгдөг гэсэн тайлбарыг нягтлан бодогч нь амаар өгч байгаа ч хэдэн ажилтанд хэчнээн нэр төрлийн хэдэн төгрөгийн материал зарцуулсныг нотлох анхан шатны баримтгүй, тайлант онд худалдан авсан зарцуулсан хүнсний материалын тооцоог хийхэд 1832.9 мянган төгрөгөөр үлдэгдэл зөрүүтэй, эд хариуцагч авч ажиллуулаагүй зөрчил байна.	440700.3	Албан шаардлага	Эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
12	2019-2020 оны нүүрсний зарцуулалтыг анхан шатны баримттай тулгахад санхүүгийн тайлан дахь нүүрсний үлдэгдлээс 80808.9 мянган төгрөгийн нүүрс бодитоор оршин байгаа эсэх нь тодорхой бус, нотлох анхан шатны баримтууд бүрэн бус учир зарцуулалтыг хянах боломжгүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй Байтаг цагаан бургаст ХХК, Минж төгөл ХХК нь 2019, 2020 онуудад тус байгууллагад нүүрсийг бүрэн нийлүүлсэн эсэх нь тодорхой бус, байгууллагын санхүүгийн баримт дахь анхан шатны баримтуудаар бүрэн нотлогдохгүй	80808.9	Албан шаардлага	Эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
13	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг <a href="http://shilendans.gov.mn">shilendans.gov.mn</a> цахим сайтад байршуулаагүй зөрчил илэрлээ.		Албан шаардлага		

14	Тайлант онд эмч ажилчдад улирлын мөнгөн урамшуулал олгохдоо ажил дүгнэснийг нотлох баримтгүй, байгууллагын даргын тушаал шийдвэргүй, жижүүрт гарсан эмч нарын энгийн өдрийн илүү цагийн хөлсийг 16 цагаар тооцон олгосон, жижүүрт гарсан эмч нь дараагийн өдөр 4 цагийг биеэр эдэлж байгаа тул илүү цагийн хөлсийг зөрүүтэй олгосон зөрчил илэрлээ.	72437.3		Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
15	2019 оны санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй эм, хүнс, бичиг хэрэг, аж ахуйн материалыг худалдан авч зарцуулсан гэсэн тайлбараар 2020 оны 1-4 саруудад ААНБ-ийн өр төлбөрийг төлсөн, тухайн оны зардлаар хүлээн зөвшөөрсөн	83291.0	Зөвлөмж өгөх	Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
16	2019 онд эмнэлгийн барилга шинээр баригдсантай холбоотой сургалтын танхимын тохижуулах зорилгоор эмч ажилчдаас 1 өдрийн цалингийн хандиваар тавилга эд хогшил хийлгэсэн боловч хэдэн нэр төрлийн тавилга эд хогшил хийлгэж хэнд хүлээлгэн өгсөн, хүлээн авсан эзэн, үнийн дүн тодорхой бус байгаагаас шалтгаалан данс бүртгэлд тусгаагүй		Зөвлөмж өгөх	Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
17	Тайлант онд бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас ирүүлсэн зарлагын баримт, нэхэмжлэхийг үндэслэн төлбөрийг төлсөн, санхүүгийн тайланд төлсөн хэмжээгээр зарлагадсан, жолоочийн тооцоо бодоогүй, эд хариуцагчийн тайлан гаргаагүй, зарцуулалтад тавих дотоод хяналт хэрэгжүүлээгүй, эмч ажилчдын Алтай таван богд явахад 750 литр шатахууныг зарцуулсан дотоод журам тусгаагүй, тушаал шийдвэргүй зарцуулсан дутагдал илэрлээ.	46168.8	Зөвлөмж өгөх	Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
18	Сүлжээний "Фохоу" ХХК-аас тосон болон бүх биеийн бариа засал хийх аппарат худалдан авахдаа харьцуулалт хийгээгүй, худалдан авах гэрээ байгуулаагүй, тоног төхөөрөмж худалдан авч төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ.	5696.0	Зөвлөмж өгөх	Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
19	Тайлант оны эцэст үндсэн хөрөнгө болон бараа материалын үлдэгдэлд тооллого хийгээгүй зарим нэр төрлийн хөрөнгө, бараа материал бодит оршин байгаа эсэх нь тодорхой бус		Зөвлөмж өгөх	Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
20	Нэгдсэн эмнэлгийн даргын 2019 оны А/17 тоот тушаалаар "Дотоод хяналтын баг" томилсон боловч хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөгүй, ажлын тайлангүй байгаа нь дотоод хяналт хэрэгжээгүй		Зөвлөмж өгөх	Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
21	Нэхст электроникс ХХК-нд 2020 оны 2 дугаар сарын 18-ны 04 тоот төлбөрийн хүсэлтээр нөтбүүк, 3 үйлдэлт принтер худалдан авахаар 2019 оны 5 сарын 27-ны өдрийн нэхэмжлэхээр төлбөрийг төлсөн боловч тус компаниас тоног төхөөрөмжийг хүлээн авсан, уг хөрөнгийг хүлээн аваагүй учраас авлагад бүртгэсэн	2400.0	Дараагийн аудитаар шалгах	Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням
22	2020 оны 1-4 сард Минж төгөл ХХК-д шатахууны үнэ 5237.6, Мөнхсүвдан гэрэл ХХК-д эмийн үнэ 15768.1, Тэнгэрийн шагай ХХК-д барилгын материал, мэс заслын болон төрөхийн даавуу, төрөхийн утас үнийг төлсөн боловч бодитоор хүлээн авсныг нотлох	28001.6	Зөвлөмж өгөх	Нэгдсэн эмнэлгийн дарга, нягтлан бодогч	Б.Батбаатар, А.Нацагбалжинням

	боломжгүй, тухайн үед ажиллаж байсан эд хариуцагч нь ажлаас гарсан тул дараагийн аудитаар авч үзэх				
	<b>ДҮН</b>	<b>980887.0</b>			

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**